

Лев Толстой. Пирогово, 1900.05.10.

ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ХИЙГЭЭД ЗАСГИЙН ГАЗАР

1

Манай энэ цаг үеийн эх оронч үзэл гэдэг бол хүмүүн төрөлхтний зовлон шаналангийн голыг бүрдүүлж буй хуурамч, бодлогогүй, хорон муу мэдрэмж юм, тийм учраас энэхүү мэдрэмжийг одоогийнх шигээ л дураар нь тавиад байж болохгүй, харин ч оюун ухаант хүмүүн бүрээс шалтгаалах бүхий л хүч бололцоогоор даран сөнөөвөл таарах зүйл хэмээн миний бие нэг бус удаа хэлж байсан билээ. Гэтэл харин ард түмнүүдийг үгүйрүүлэн хоосруулагч бүх нийтийн зэвсэглэл, хөнөөлт дайнууд чухамхүү энэ л мэдрэмжнээс маргашгүй ихээр хамаараад байгааг үл хайхран, эх оронч үзлийн хор нөлөө, цаг хугацааны үл тохироо, хоцрогдлын талаар хэлээд байгаа зүйлсийг маань одоог хүртэл үл анзааран, эсбөгөөс зориудаар үл ойлгосон дүрээр хүлээн авахгүй байгаа нь тун хачирхалтай. Тэр ч бүү хэл, хэт тэнэг эх оронч үзэл, шовинизм, жингоизм (хэт шовинист, хэт империалист үзлийн нэр томъёо. Орч) л хортой болохоос бус, жинхэнэ, ариун нандин эх оронч үзэл гэдэг бол эрхэм дээд ёс суртахууны мэдрэмж учир түүнийг шүүмжлэх нь ухаангүй явдал байтугай, гэмт хэрэг мөнөөс мөн хэмээх нь сонин. Харин тэрхүү жинхэнэ, ариун нандин эх оронч үзэл гээч юм нь юу болох тухай эсвэл таг дуугүй сууцгаах, эсвэл аливаа тайлбарын оронд гоёж гогоодсон бардам, ихэрхүү үгсийг зүүн, баруунгүй шидлэх, эс бөгөөс бүр байчихаад эх оронч үзэл гэгчийг бидний өнөөх сайн мэддэг агаад түүнээсээ болоод зовлонд үйж байгаа эх оронч үзэл гэгчтэй огт хавирахгүй зүйлээр тайлбарлаад унах ажгуу. Уг нь жинхэнэ, ариун нандин эх оронч үзлийн мөн чанар бол өөрийн ард түмэн хийгээд төр улсдаа бусад ард түмнүүдийн сайн сайхныг үл хөндөх аз жаргалыг хүсэхэд л оршино хэмээцгээх бөлгөө.

Эдүгээ болж буй дайн байлдааны талаар саявтархан би нэг англи хүнтэй ярилцаж байхдаа энэхүү дайны жинхэнэ шалтгаан бол хүн бүхний хараагаад байгаа шиг хэн нэгний амин хувийн ашиг сонирхлоос болоогүй юм, чухам шалтгаан нь гэвэл эх оронч үзэл юм, үүнийг Английн нийгмийн сэтгэл зүйгээс ч харахад ойлгомжтой байна шүү дээ гэгчихсэн юм. Гэтэл өнөөх англи хүн маань надтай санал нийлээгүйгээр үл барам, хэрвээ тийм юм бол өдгөө цагт англичуудыг зоригжуулаад байгаа эх оронч үзэл бол шал тэнэг эх оронч үзэл байж таарна, гэтэл үнэн чанартаа англичуудын сэтгэл зүрхэнд нэвт шингэсэн эх оронч үзэл санаа бол тэднийг тэнэг үйлдэл хийлгэхгүй байхад л орших үзэл санаа юм гэдэг байгаа.

-Та тэгээд зөвхөн өөрийн англичуудаа л тэнэг юм битгий хийгээсэй гэж хүсээд байгаа юм биз дээ? хэмээн намайг асуутал урдаас маань:

-Бүх хүмүүсийг битгий тэгээсэй гэж хүсэж байна хэмээн хариулж билээ. Гэхдээ жинхэнэ сайн сайхны, тэр нь ёс суртахууны ч бай, шинжлэх ухааны ч бай, хавсарга ч бай, ахуйн ч бай ялгаагүй мөн чанар гээч бол хүн бүхэнд хамааралтай байдаг тул аливаа хүнд сайн сайхныг хүсэх нь эх оронч үзэл бишээс гадна, түүнийг ч үгүйсгэж байгаа хэрэг юм гэсэн санаа тэр англи хүний хариултаас илэрч байсан юм.

Яг үүнчлэн, эх оронч үзлийн халхавчин дор шургуулах гээд байгаа аливаа ард түмний онцлог ч эх оронч үзэл биш ээ. Аливаа ард түмний онцлог бол хүмүүн төрөлхтний хөгжил дэвшлийн гол нөхцөл учраас тэрхүү онцлогуудыг хадгалан

үлдээхийг хүсэж буй эх оронч үзэл бол ашигтай сайн зүйл хэмээн дээрхи хүмүүс хэлдэг. Аль нэг ард түмний онцлог, шашин шүтлэг, зан заншил, хэл нэгэн цагт хүмүүн төрөлхтний амьдралын гол нөхцөл болж байсан нь үнэн хэдий ч, одоо бол тэдгээр онцлогууд нь хүн бүхний ухамсарт нэгэнт бат нот шингэсэн ард түмнүүдийн ах дүүгийн эв нэгдлийн хэрэгжилтэнд гол саад болоод байгаа юм. Тийм болохоор орос, немец, франц, англосаксон ч бай, аль нэг ард түмний онцлогийг хадгалан дэмжиж, үүгээрээ зөвхөн унгар, польш, ирланд ч биш, мөн баск, провансал, мордов, чуваш гээд бусад олон ястнуудыг хадгалан үлдээх гэсэн оролдлого нь хүмүүсийг ойртуулан нягтруулах бус, харин ч улам холдуулж, хэсэглэн хуваахад түлхэц болно.

Ингээд үзэхэд, бидний сайн мэддэг тэр эх оронч үзэл гэдэг бол, өнөө цагийн олонхи хүмүүс нөлөөнд нь орсон, хүн төрөлхтөн ч гашуунаар зовж зүдэрч байгаа эх оронч үзэл гэдэг бол зөвхөн өөрийнхөө ард түмэнд оюун санааны сайн сайхныг хүсэх, ард түмнүүдийн өөр өөрийн онцлогийг хадгалан оршиход ч биш, харин өөрийн ард түмэн, төр улсаа бусад ард түмэн, төр улсаас илүүд үзэх мэдрэмж, бусад ард түмэн, төр улсын хүчирхэг байдал, сайн сайхан амьдралд хохирол учруулан байж өөрийн ард түмэн, төр улсаа хамгийн хүчирхэг, сайн сайхан амьдралтай байлгах гэсэн оролдлого болж таарлаа.

Аливаа ард түмэн, төр улс өөрийгөө бусад ард түмэн, төр улсуудаас хамгийн сайн нь хэмээн тооцдог юм чинь эх оронч үзэл гэдэг бол мэдрэмж болохынхоо хувьд хамгийн тэнэг агаад хамгийн хортой мэдрэмж, эх оронч үзлийн сургааль гэдэг нь ч мөн адил хамгийн тэнэг сургааль болой.

2

Уг нь эх оронч үзлийн хор уршиг, тэнэглэл бүх хүмүүст ойлгомжтой баймаар. Гэтэл гэгээрсэн, оюунлаг хүмүүс үүнийгээ үл ухахын хажуугаар, эх оронч үзлийнхээ хор хөнөөлийг гайхалтай шаргуугаар хамгаалаад, эрхэм дээд ашиг тусыг нь улам магтаад байгаа нь сонин.

Энэ нь одоо юу гэсэн үг вэ?

Хачирхалтай энэ үзэгдлийн цор ганц тайлбарыг хэлэхийг хүснэм би. Хүмүүн төрөлхтний цадиг шасдирыг эрт цагаас авахуулаад өнөө манай үеийг хүртэл тус тусдаа хүмүүсийн ч, бүлэг бүлэг хүмүүсийн ч оюун ухааны хөдөлгөөн, доод үзэл санаанаас дээд үзэл санаанд хүрсэн хөдөлгөөн хэмээн үзэж болно.

Ганц хүний ч бай, хэсэг бусаг хүмүүсийн ч бай туулж өнгөрсөн зам мөрийг адгуусны амьдралын төвшний хамгийн доод гишгүүрээс одоогийн түүхэн агшинд хүмүүн бээрийн ухамсрын гараад буй дээд гишгүүр хэмээн үзвэл зохино. Нэг хүн ч бай, нэгдэн нийлсэн хэсэг хүмүүс, ард түмэн, төр улс ч бай ялгаагүй, үзэл санааны тэдгээр гишгүүрүүдийг л дамжсан, дамжсаар ч яваа. Хүмүүн төрөлхтний нэгэн хэсэг нь түрүүлж, нөгөө хэсэг нь хожигдож, харин гуравдахь хэсэг нь буюу олонхи нь дунд хавьд нь яваа. Харин уг шатны аль гишгүүр дээр зогсож байгаагаасаа үл хамааран аль нь ч гэсэн доод үзэл санаанаас дээд рүүгээ тэмүүлж яваа. Яг үүн лүгээ нэгэн адил эхэн, дунд, адгийн шатан дээр зогсож буй тухайн хүн ч бай, түшиг тулгуур болон нэгдсэн бүлэг хүмүүс ч бай ялгаагүй, тодорхой агшиндаа мөн л үзэл санааныхаа гурван шатны гурван өөр харилцаанд оршиж байдаг.

Нэг хүний хувьд ч бай, нэг хэсэг хүмүүсийн хувьд ч бай ялгаагүй, нэгэнт туулаад, дахиад эргээд гишгэхгүйгээр харшил болгон үлдээсэн үзэл санаа гэж байдаг.

Тухайлбал, манай Христийн ертөнцийн хувьд бие биеэ барьж идэх, бүх нийтээрээ

дээрэм тонуул хийх, эмс, охидыг хулгайлан эхнэрээ болгох гэх мэтийн дурсамжууд болно. Энэ бүхнээс гадна бас тухайн амьдарч буй цагийнх нь хүмүүжил, үлгэр дуурайл, хүрээлэн буй орчных нь үйл ажиллагаанаас хамаарсан, заавал дагахаас аргагүй үзэл санаа гэж буй. Тухайлбал, өнөөгийн бидний үеийн өмчийн үзэл, төрийн байгууламжийн үзэл санаа, худалдаа наймаа, гэрийн тэжээмэл амьтдын талаархи үзэл бодол ч үүнд хамаатай. Тэр бүхний хажуугаар зарим хүмүүсийн хувьд хэзээ мөдгүй хэрэгжихэд бэлэн, аль эсвэл зарим хүмүүсийг урьдынхаа хэвшлийг өөрчилж, амьдралынхаа төлөө тэмцэхээс аргагүйд хүргэж буй ирээдүйн үзэл санаа бас байна аа. Тухайлбал, ажилчин ангийг чөлөөлөх, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, махаар хооллохоос татгалзах зэрэг үзлийг хүмүүс аль эрт ойлгон хүлээж авсан ч гэсэн, гагцхүү урьдынхаа хэвшилтэй тэмцэхээс түдгэлзээд байгааг хэлвээс зохилтой. Ийнхүү манай энэ цаг үеийн үзэл санаа хэмээн нэрлээд байгаа үзлүүдийн тоонд хүчирхийллийг устгах, өмчийг нийтийн болгох, нэг шажныг дагах, бүх нийтээрээ ахан дүүс бололцох зэрэг үзлүүд орно.

Ингээд үзэхэд, нэг хүн ч бай, нэг хэсэг хүмүүс ч бай хөгжлийн аль гишгүүр дээр зогсож буйгаасаа үл хамааран, өнгөрсний дурсамжийг ардаа орхиод, ирээдүйн үзэл санааг урдаа хараад, үеэ өнгөрөөсөн хийгээд ирээдүйд угтан тосож буй тэмцлийн эрхшээлд оршиж байдаг юм. Туулж өнгөрсөн зам дээр нь зайлшгүй агаад ашиг тустайд тооцогдож байсан үзэл санаа нэгэнт хоцрогдоод, их, бага ямарваа тэмцлийн дараа урьд нь мөрөөдөл төдий байсан шинэ үзэл санаанд байраа тавьж өгдөг.

Гэтэл шинэ үзэлд байраа тавьж өгсөн тэр хуучин, хоцрогдсон үзэл санаанаасаа зууралдаад байх нь нийгмийн нөлөө бүхий зарим хүмүүст ашигтай байх тал бий. Тэрхүү хоцрогдсон үзэл нь амьдралын олон талын харилцаанд нэгэнт нэвтэрсэн шинэ үзэл санаатай зөрчилдөөд байлаа ч гэсэн, олон хүмүүст нөлөөлж, үйл ажиллагааг нь удирдахад хүрэх нь бий. Хоцрогдсон үзэл санааны иймэрхүү саад тотгор ялангуяа шашин шүтлэгийн салбарт их ажиглагддаг. Үүний шалтгаан нь аливаа шажин суртлын үеэ өнгөрөөсөн үзэл санааны ачаар урьдын байр сууриа хадгалахыг хүсдэг бөө удгануудтай холбоотой. Төрийн ямарваа байгуулалтын суртал дээр үндэслэгдсэн эх оронч үзэлд ч төр улс яг л ийм шалтгаанаар ханддаг. Өөрт нь юу ч, ямар ч хамаагүй хүмүүс л иймэрхүү хандлагыг зохиомлоор дэмжиж байдаг. Хүмүүст асар хүчирхэг нөлөөтэй байдаг төр үүнийг дор нь зохион байгуулчихаж чадна л даа.

Христийн шүтлэгтэй ертөнцийн оюун ухаанд нэгэнт нэвтэрсэн шинэлэг үзэл санаа, үеэ өнгөрөөсөн эх оронч үзэл санаа хоёрын хачирхалтай зөрчилдөөний талаар миний өгөх тайлбар ийм байна.

3

Эх оронч үзэл нь өөрийнхөө ард түмэнд цаглашгүй хайртай гэх мэдрэмжийн баталгаа болохын хувьд, мөн дайсныхаа хүчирхийлэл, дарлалаас сул доройчуулыг хамгаалахын тулд амар амгалан аж төрөх, өмч хөрөнгө, амьдралаа ч золиосолж чадах гавъяат үйл хэргийн сургааль болохын хувьд нэгэн цагийн дээд үзэл санаа байжээ. Тэр цаг үед аливаа ард түмэн өөрийнхөө сайн сайхан амьдрал, хүчирхэг байдлын төлөө өөр ард түмнийг дээрэмдэн тонох, дарлан мөлжих үйл шударгад тооцогддог байж. Гэвч 2000 орчим жилийн өмнөөс хүмүүн төрөлхтний шилдэг мэргэдийн ач буянаар хүмүүсийн ахан дүүсэг харилцааны дээд үзэл санаа бүрэлдэн тогтож эхлээд, оюун санаанд нь аажим аажмаар нэвтэрсээр, эдүгээ цагт

янз бүрийн замаар хэрэгжээд эхэлж байна. Мэдээллийн хэрэгслүүд хөгжиж, худалдаа, аж үйлдвэр, соёл урлаг нэгдэн нягтарч, хүмүүсийн мэдлэг өргөжсөний хэрээр ард түмнүүд ч нягт холбоотой болов. Үүний үрээр эзлэн түрэмгийлэл, алаан хядаан, хөрш зэргэлдээ орших улс гүрний хүчирхийллийн аюул бүрмөсөн арилж, бүх ард түмнүүд (засгийн газрууд биш шүү) өөр хоорондоо энх амгалан, харилцан ашигтай, нөхөрсөг худалдаа, аж үйлдвэр, оюун санааны харилцаанд орсноор тэрхүү харилцааг бусниулах нь ямар ч утга байхгүй гэдгийг ухамсарлах болов. Ингэснээр үеэ өнгөрөөсөн эх оронч үзлийн мэдрэмж одоо цагт илүүдэлтэй бөгөөд амьдралд нэгэнт нэвтрэн орсон олон янзын үндэстэн, ястнуудын ахан дүүгийн харилцааны ухамсартай яавч нийцэхгүй учир аажим аажмаар алга болно хэмээн бодмоор. Гэтэл шал эсрэгээрээ болоод, хар хортой, үеэ өнгөрөөсөн мөнөөхөн мэдрэмж амь бөхтэй оршсоор байгаагаар үл барам, харин ч улам хүчээ авч эхлэв. Бусад улс үндэстэн рүү халдан довтолж, харийн өмчийг булаан авч, эзлэн авсныгаа хүчирхийллээр улайран хамгаалж буй засгийн газраа ард түмэн нь өөртөө ямар ч ашиггүйгээр, ухамсар сэтгэхүйнхээ эсрэгээр өөгшүүлэхээр үл барам, хэдийгээр өөрсдөө тийн халдан довтолж, эзлэн түрэмгийлж өөрийн болгоогүй ч гэсэн асар ихээр хөөрөн баясаж, бардамнан бахархах ажгуу. Их гүрнүүдийн захиргаанд орсон польш, ирланд, чех, финланд, армен зэрэг жижиг үндэстнүүд хүчирхэг эзлэн түрэмгийлэгчдийнхээ эх оронч үзлийн дарангуйлал дор улам улайраад, тэр үзэл санааны халдвар аваад, тэднийхээ л хийсний нэгэн адил хорон үйлийг бусад үндэстэнд үзүүлэх болов.

Олон түмэнтэй харьцуулах юм бол, засаглалыг баригч ангиуд (Үүнд зөвхөн засгийн газрууд болон тэдгээрийн түшмэлүүд ороод зогсохгүй, басхүү өндөр ашигтай байр суурь эзэлдэг капиталистууд, сэтгүүлчид, олонхи уран бүтээлчид, эрдэмтэд багтана) эх оронч үзлийн хүчээр л оршин тогтнож байдаг төрийн байгууллагын буянаар асар их ашигтай байр суурийг эзэлж байдаг учир энэ бүх юм болоод байгаа хэрэг. Ард түмэнд нөлөөлөх гайхалтай хүчирхэг арга хэрэгслийг гартаа хийчихсэн болохоор тэдбээр өөрийнхөө болон бусдын эх оронч үзлийг хэлбэрэлтгүй хөгжүүлж, тэгснээрээ төрийн засаглалыг тэтгэж, тэр засгийнхаа ч зүгээс бусдаас илүү шагнал харамж хүртэнэ.

Аливаа түшмэл хэдий хэрийн их эх оронч байна, төдийчинээ өндөр албан тушаалд хүрнэ. Цэргийн албан хаагч ч ялгаагүй, эх оронч үзлээр жигүүрлэсэн дайн тулааны үйлээр цол, зэрэг ахина.

Эх оронч үзэл хийгээд түүний үр дагавар болсон дайн байлдаан сонинчид (сурвалжлагч, сэтгүүлчид. Орч) болон наймаачдад гайхалтай өндөр ашиг авчирна. Аливаа зохиолч, багш, профессор эх оронч үзлийг хэдийчинээ сайн сурталдана, төдий хэрээр байр сууриа илүү бэхжүүлнэ. Аливаа эзэн хаан, ван, гүн эх оронч үзэлд хичнээн үнэнч байх тусам, алдар нэр нь төчнөөн их цуурайтна.

Засаглалыг баригч ангиудын гарт цэрэг арми, хөрөнгө мөнгө, сургууль, шашин, хэвлэл байна. Сургуулийн анги танхимд тэднүүс өөрийн ард түмнээ хамгийн сайн, хамгийн ариун шударга ард түмэн хэмээн мунхруулж, эх оронч үзлийн түүхээр хүүхдүүдийг мунхруулна. Харин томчуулд нь тэднүүс энэ мэдрэмжийг элдэв төрлийн үзвэр, баяр ёслол, хөшөө дурсгал, худал хуурмаг эх оронч дүртэй хэвлэл мэдээллийн хэрэгслийнхээ хүчээр асааж өгнө дөө. Хамгийн гол нь, тэднүүс өөр үндэстний эсрэг зүсэн бүрийн харгислал, шударга бус явдлыг хэрэглэснээрээ

өөрийнхөө ард түмэнд дайсагнах үзлийг өөрсдийнхөндөө төрүүлнэ, дараа нь тэрхүү дайсагналыг ард түмнийхээ эсрэг хэрэглэнэ. Энэхүү аймшигт эх оронч мэдрэмжийг дэвэргэх үйл хэрэг Европын орнуудад гайхалтай дэвшилттэй өрнөөд, одоо цагт хамгийн дээд гишгүүр дээрээ гарчээ. Цаашаа алхах зам байхгүй.

4

Христийн шүтлэгт ертөнцийн хүмүүсийг эх оронч үзэл ямар гээчийн тэнэглэлд хүргэснийг манай эриний тийм ч ахимаг насны хүмүүсийн ой дурдатгал мартаагүй ээ. Германы эрх баригч ангиуд 19 дүгээр зууны хоёрдугаар хагасад бүх нийтийн цэргийн үүргийн тухай хууль гаргаж, олон түмнийхээ сэтгэлд эх оронч үзлийг унтаршгүйгээр асаасан. Уг хуулийн дагуу хүү нар, аав нар, эрдэмтэд, ариун гэгээн санваартнууд ч хүн алах эрдэмд суралцаж, даргынхаа эзэмшилд орох тушаал авсан. “Хэн рүү заана, түүнийг хорооход цаг ямагт бэлэн бай, манай эзэрхийлэлд орсон үндэстний иргэд, эрх чөлөөнийхөө төлөө тэмцсэн ажилчид, аав нар, ах, дүүсээ егүүтгэтүгэй!” хэмээн бүх цаг үеийн хамгийн харгис эзэн хаан Вильгельм II ил тодоор зарласан.

Хүмүүн заяатны хамгийн ариун мэдрэмжийг хамгийн бүдүүлгээр доромжилсон энэхүү арга хэмжээг эх оронч үзлийн нөлөөн дор Германы ард түмэн ямар ч эргэлзээ тээнэгэлзэлгүйгээр хүлээн авсан. Түүний хор уршгаар француудыг ялсан. Тэрхүү ялалт Германы, тэгээд Франц, Орос болон бусад гүрнүүдийн эх оронч үзлийг улам дэвэргэж, эх газрын улсуудын иргэн бүрийг бүх нийтээр цэргийн албан хаах үүрэгт унагасан. Энэ бол доромжлол, дарлагдлынхаа зэрэглэлээр эртний боолчлолтой ч хавирахгүй том эмгэнэл байлаа. Ингэснээр ард түмэн нь эх оронч үзлийн тусын тулд боолын номхролд орж, засгийн газрын харгислал, хэрцгийлэл, тэнэглэлд хязгаар байхаа больсон. Ази, Африк, Америкийн газар нутгийг шунал тэчьеэл, нэр хүндийнхээ эрхшээлээр дуу дуугаа авалцан эзлэн түрэмхийлж, улс гүрнүүдийн засгийн газрууд бие биедээ улам улмаар итгэхээ болиод хар хорыг шидэлцэж эхэлсэн.

Эзлэн түрэмхийлсэн газар нутгийнхаа хүн ардыг хүйс тэмтрэх ажил ердийн зүйл болсон. Асуудлын гол нь тухайн нутаг орныг хэн нь түрүүлэн эзэлж авах, хүн ардыг хэн нь түрүүлэн хүйс тэмтрэхэд л оршиж байна. Засгийн газар бүр эзлэгдсэн ард түмнүүдийнхээ эсрэг үйлдэж буй гэмт хэрэгтээ хүй нэгдлийн үеийн хүмүүсийн шулуун шударга чанарын хамгийн наад захын хэм хэмжээг ч зөрчсөн, зөрчсөөр ч байгаагаар үл барам, худал хуурмаг, ов мэх, хулгай луйвар, хээл хахууль, тагнуул тандалт, дээрэм тонуул, аллага хядлага үйлдсээр л, ард түмнүүд нь харин тэр бүхэнд харамсах нь байтугай, улам өөгшүүлсээр л байсан, одоо ч өөгшүүлсээр л байгаа, аль нэг өөр улс гүрэн биш, харин өөрийнх нь улс гүрэн энэ бузар булайг үйлдсээр буйд баярлан талархсаар л суугаа. Ард түмнүүд хийгээд төр улсуудын харилцан дайсагнал сүүлийн үед бүр ч туйлдаа хүрээд, хэдийгээр нэг нь нөгөө рүүгээ халдан довтолох өчүүхэн шалтгаан байхгүй ч гэсэн, бүгдээрээ л шүдээ ярзайлган, хумсаа сэрийлгэн хэн нэгнийгээ жаахан ч гэсэн сульдах таатай

нөхцлийг хүлээн, өөрсөддөө аль болох аюул багатайгаар дайран ороод тасчин хаяхаар зэхэж байна.

Христийн шүтлэгтэй гэгдэх энэхүү ертөнцийн ард түмнүүд эх оронч үзлээрээ араатан төрхөд хувилаад, алах юм уу, алагдах заяанд унасан хүмүүс нь ч аливаа аллагыг хүсэх, эсбөгөөс хөөрцөглөн үзэх нь гаараад, Европ дахь, хэний ч заналхийлэлгүй гэр орондоо амар мэнд аж төрж буй иргэд нь ч, Европ, Америкийн иргэд ч ялгаагүй ямар ч дайн болж байсан үл ажран, Римийн циркийн үзэгч аятай налайн суугаад, холбоо, мэдээллийн хөгжлийн ач тусаар аливаа аллагад хөөрцөглөн баясаж, “Pollice verso!” (итал. “Толгойг нь ав!”???) хэмээн хашгиралдаж байна.

Томчуул ч бус, бас хүүхдүүд, цэвэр ариун, үндэс угсаагаар нь шинжвээс мэргэн цэцэн нялхас ч мөн адил 700 биш, 1000 англи, эсвэл эзэн хүн лиддитэн суманд (цагаан дариар цэнэглэсэн сум. Орч) амиа алдахыг хараад хөөр баяр болж байна. Эцэг, эх нь ч гэсэн тэднийгээ өөгшүүлж байгааг миний бие сайн мэднэ.

Энэ ч бас бага хэрэг. Нэг гүрэн цэргийнхээ тоог нэмэх нь (Аюулд орсон хэн нь ч эх оронч үзлийн үүднээс цэргээ нэмэхийг оролддог) хөрш гүрэнд нь эх оронч үзлийнхээ үүднээс цэргийнхээ тоог нэмэх шалтаг болох агаад түүнийг нь дуулчихаад эхнийх нь ч мөн дахиад л нэмж эхэлнэ. Хэрэм цайз, тэнгисийн цэрэг ч ялгаагүй. Нэг улс 10 хуягт онгоц хийчихвэл хөршүүд нь 11-ийг хийнэ, эхнийх нь тэгтэл 12 болгоно гэх мэтээр хязгааргүй дэвшлийг баримтлаад эхэлнэ дээ.

-“Би чамайг чимхэнэ.

-Тэгвэл би зангидсан гараараа.

-Би тэгвэл ташуурдана.

-Тэгвэл чинь би мунадана даа.

-Тэгвэл би буудлаа шүү”...

Уг нь ингэж дүрсгүй хүүхдүүд ч юм уу, согтуу хүмүүс, араатан амьтад л муудалцдаг баймаар, гэтэл ийм тоглоомоор соёлжсон гүрнүүдийн өндөрлөгүүд, албат нарынхаа ёс суртахуун, хүмүүжлийг удирдан чиглүүлэгч нар нь өөрсдийгөө зугаацуулж байна.

5

Нөхцөл байдал улам дордсоор, мөхөл рүү нь хөтөлж буй энэ нөхцөл байдлыг зогсоох ямар ч боломжгүй болжээ. Итгэх дуртай хүмүүсийн цорын ганц найдлага болж байсан сүүлчийн үйл явдал будаа боллоо. Гаагын чуулган (Оросын Засгийн газрын санаачлагаар 1899 онд болсон Гаагын 1-р чуулганд 27 орон оролцсон. Орч), түүний дараахан эхэлсэн Англи, Трансвааль хоёрын дайныг (Одоогийн ӨАБНУ-ыг Их Британий цэрэг эзлэн түрэмгийлсэн 1899-1902 оны дайныг хэлж байна. Орч) би хэлээд байна л даа.

Олон улсын шүүх дайны хор хөнөөл, улам улмаар өсөх зэвсэглэлийг хориглож чадна хэмээн өнгөц дүгнэдэг хүмүүс тэр чуулганд их найдвар тавьж байсан боловч, Гаагын чуулган хийгээд, түүний дараа эхэлсэн уг дайн энэ асуудлыг энх тайвны замаар шийдэж болохгүйг харууллаа. Цэрэг, армитай засгийн газрууд оршин тогтнож байгаа цагт зэвсэглэлийг хорогдуулах, дайныг хорих ямар ч боломжгүй гэдгийг Гаагын чуулган нотлов. Ямар ч хэлэлцээрийг хийхийн тулд зөвшөөрөлцөж буй талууд бие биедээ итгэх нь чухал. Гүрэн улсууд бие биедээ итгэхийн тулд зөвлөлдөөнд орж буй бүрэн эрхэт төлөөлөгчдийн нэгэн адил, онилсон зэвсгээ үүрэх ёстой. Засгийн газрууд бие биедээ үл итгэн, цэрэг армиа

устгах нь бүү хэл, цөөрүүлэх ч үгүй, харин ч хөрш орныхоо нэгэн адил өсгөөд л байх юм бол, ямар ч улс өөр лүү нь боломж л олдвол дайрч мэднэ хэмээн хар санаад цэрэг дайчдынх нь хөдөлгөөн бүрийг тандаад байх юм бол ямар ч хэлэлцээр хийх боломжгүй. Энэ талын ямар ч чуулган тэнэглэл юм уу дүрсгүйтэл, эсвэл худлаа зүйл, эсвэл харгислал, эсвэл бүр аль алиных нь холион бантан болж таарна.

Чухамдаа гэвэл, Оросын засгийн газар л уг чуулганы хэнээс ч илүү “enfant terrible” (эрх хүүхэд) байж чадах байсан юм. Эх оронд нь хэн ч өөрийнх нь элдвийн худал хуурмаг уриа лоозон, хааных нь илгээлтүүдийн төлөө буруутгадаггүйг манай засгийн газар ашиглан, зэр зэвсгээ нэмэгдүүлснээр ард түмнээ ямар ч эргэлзээ тээнэгэлзэлгүйгээр хоосруулж, Польшийг багалзуурдаж, Туркестан, Хятадыг тонон дээрэмдэж, Финляндын хоолойд бол бүр ч хорсолтойгоор асчихаад, өөрт нь итгэнэ гэсэн бат найдлагаар бусад засгийн газруудад зэвсэглэлээ хорогдуулахыг санал болгож байлаа.

Ялангуяа өөрсдөө цэрэг, зэвсгээ нэмэгдүүлэх талаар шийд гаргачихсан мөртлөө бусад засгийн газруудыг хараажийн худал хуурмаг, шал инээдэмтэй зөвлөлдөөнөөс татгалзаж болохгүй нөхцөл байдалд оруулчихаад байсан үед уг санал нь хачирхалтай, гэнэтийн, асар бүдүүлэг байлаа. Тэр зөвлөлдөөн олигтой юманд огт хүрэхгүй гэдгийг мэдсээр байсан ч гэсэн, улс орнуудын төлөөлөгчид нэгэнт хуран цугларчихаад шал дэмий хэдэн сарыг өнгөрөөж, цалин пүнлүүгээ тоо ёсоор нь хүртэж, нударгандаа хоншоороо нуун инээж, ард түмнүүдийн дунд эв найрамдал тогтоох гээд байгаад дургүйцэж байгаагаа нууж байлаа.

Зогсоох талаар хэн ч, ямар ч оролдлого хийгээгүй Трансваалийн дайнаар дууссан Гаагын чуулган анх санасныг бодвол харин ч ашигтайгаар төгссөн юм. Хамгийн гол нь, ард түмнүүдийн зовлонгийн эх болсон хорон үйлийн алдааг засгийн газрууд засаж чадахгүй, засахыг хичээлээ ч гэсэн дайныг ч, зэр зэвсгийг ч үгүй болгож чадахгүй гэдэг нь нотлогдсон. Оршин тогтнож байхынхаа тулд засгийн газар өөрийнхөө ард түмнийг өөр бусад ард түмний түрэмгийллээс хамгаалах үүрэгтэй, гэвч ямар ч ард түмэн өөрөө аль нэг ард түмэн рүү дайран довтолдоггүй болохоор засгийн газрууд л энх тайвныг хүсэх нь бүү хэл, харин ч бусад ард түмнүүдийн үзэн ядалтыг дандаа өдөөж байдаг юм. Өөр ард түмний дургүйцэл, үзэн ядалтыг төрүүлчихээд, өөрийнхөө ард түмний сэтгэлд эх оронч үзэл гээчийг асаачихсан хойноо засгийн газрууд аюулд орчихоод байна, хамгаалах хэрэгтэй боллоо хэмээн итгүүлж эхэлдэг.

Тэдэнд өөр хийх зүйл байхгүй, яагаад гэвэл энэ нь л тэдний оршин тогтнох эх сурвалж нь билээ. Хэрвээ урьд нь засгийн газрууд өөрийнхөө ард түмнийг бусдын довтолгооноос хамгаалахын тулд хэрэгтэй байсан бол одоо харин шал эсрэгээрээ, ард түмнүүдийн эв нэгдлийг зориудаар бусниулж, хооронд нь дайсагналцуулах болов.

Тариа тарихын тулд газар хагалах хэрэгтэй бол тэр нь зөв, харин тариа ургачихсан хойно газар хагалах нь хамгийн тэнэг ажил. Гэтэл засгийн газрынх нь зүгээс ийм л юм хийхийг ард түмнээсээ шаардаад байгаа юм. Засгийн газрууд байгаагүйсэн бол ард түмнүүдийн эв нэгдэл хэзээ ч алдагдахгүй байхсан.

6

Ер нь ингэхэд манай энэ цаг үед хүмүүс өөргүйгээр нь оршин тогтнож үл чадах засгийн газрууд гэдэг юу юм бэ?

Нэгэн цагт засгийн газар бага ч гэсэн хэрэгтэй, зохион байгуулалттай хөршүүдийнхээ довтолгооноос ард түмнээ хамгаалж чадахгүйгээс өөр хорон муу үйлгүй байсан бол одоо харин засгийн газар огт хэрэггүй, ард түмнээ айлгах л гайхалтай их хорон муу үйлээс өөр юм хийхээ больжээ.

Зөвхөн цэргийн эрхтнүүдийн засгийн газар ч биш, ер нь л аливаа засгийн газрууд одоогийн хятадуудын хийхээр төсөөлж байгаагийн нэгэн адил ямар ч нүгэлгүй, цэвэр ариун хүмүүсээс бүтдэг байсансан бол ашиггүй юм гэхэд хоргүй байж болохсанж. Гэвч үйл ажиллагаанаас нь хараад байх юм бол хүчирхийлэл явуулахад л оршдог үүрэгтэй засгийн газрууд хамгийн эсрэг, тэсрэг үзэл бодолтой, хамгийн харгис, хамгийн бүдүүлэг, хамгийн садар хүмүүсээс бүрдээд байх болжээ. Ингээд үзэхэд засгийн газар, нэн ялангуяа цэргийн эрхтнүүдийн засгийн газар бол энэ хорвоо дээрхи хамгийн аюултай бөгөөд хамгийн аймшигтай байгууллага болон хувирч байна. Өргөн утгаараа засгийн газар, өөрийнхөө капиталистууд хийгээд хэвлэлийнхнийг оруулаад цөөнхийн дээр засаглан зогсогч олонхийн байгууллага юм. Тэр цөөнх нь дахиад нэг жижигхэн цөөнхөд, энэ цөөнх нь бүр илүү жижигхэн цөөнхөд захирагдан, цааш явсаар ердөө л хэдхэн хүнд юм уу, цорын ганц хүнд захирагдах бөгөөд, чухамхүү эднүүс л бусад бүх хүмүүсийг цэргийн засаглалын хүчээр гартаа хийжээ.

Өөрөөр хэлбэл, энэ байгууллага бол яг л конус адил, түүний оройд зогсох ганц юм уу, хэдхэн хүний бүрэн захиргаанд бусад нь оржээ. Конусын оройг бусдаасаа хамгийн их зальтай, хамгийн их овсгоотой, хамгийн хүйтэн сэтгэлтэй нэг юм уу, хэдэн хүн, аль эсвэл хамгийн хэрцгий, хамгийн хүнтэн сэтгэлтэй хүмүүсийн тохиолдлын өв залгамжлагчид эзлэн сууна.

Өнөөдөр тэр нь Борис Годунов, маргааш Григорий Отрепьев, нууц амрагуудынхаа гараар нөхрөө боомилсон садар эм Екатерина, маргааш Пугачев, нөгөөдөр болохоор тэнэг Павел, Николай, III Александр. Одоо Наполеон, маргааш Бурбон юм уу, Орлеанский, Буланже, эсвэл Панамын бүлгийнхэн, өнөөдөр Гладстон, маргааш Сольсбери, Чемберлен, Роде.

Ийм л засгийн газруудын гарт бид зөвхөн өмчийнхөө бүрэн засаглалыг ч биш, мөн аж төрөл, сэтгэл санааны хийгээд ёс суртахууны хөгжил, хүмүүжил, шашин бишрэлийн удирдлагаа тушаачихжээ. Аль таарсанд нь засгийн эрхийг өгчихөөд (Засгийн эрхийг хамгийн олиггүй хүн авдаг нь ойлгомжтой), засаглалын аймшигт машиныг бий болгочихоод, өмнө нь боол адил бөхийчихөөд, эцсийн эцэст өөрсдийнхөө тэнэгийг гайхан суух аж. Хүмүүс галт бөмбөг, анархистуудаас айдаг атлаа агуу их гашуун зовлонг агшин тутамд хөтлөн ирэгч энэ аймшигт байгуулалтаасаа айж үл мэдэх ажгуу.

Дайснуудаасаа хамгаалахын тулд өөрсдийгөө хүлээсэнд оруулах нь ашигтай гэдгийг хүмүүс бодоод олчихсон байх юм. Черкесүүд яг л тийм юм хийсэн шүү дээ. Аюул байхгүй ч үед хүмүүс өөрсдийгөө хүлээсэнд оруулсан хэвээр.

Өөрийгөө гайгүй сайн хүлж аваад, өөр нэг, захын зальжин тэнэг хүрч ирээд дуртай зүйлээ хийх боломж олгохын тулд оосрынхоо нөгөө үзүүрийг сул хаячихна. Тэгсэн хойно өөрт нь хичнээн хэцүү байгааг гайхаж эхэлнэ дээ.

Ард түмэн маань цэргийн засаглалтай холилдсон засгийн газрыг дэмжээд, эмхлэн байгуулаад, үг дуугүй захирагдахаас өөр юм юу хийж байгаа юм бэ?

Тэсвэрлэхийн аргагүй, тасралтгүй өсөн нэмэгдэх дайн байлдаан, зэр зэвсгийн аймшигт, гашуун зовлонгоос хүмүүсийг чөлөөлөхийн тулд чуулган, бага хурлууд ч хэрэггүй, сургааль, шүүх ч хэрэггүй, харин хүмүүсийн аймшигт тарчлааны эх сурвалж болсон “засгийн газар” хэмээгч хүчирхийллийн зэвсгийг л устгах хэрэгтэй юм.

Засгийн газрыг устгахын тулд ганцхан юм л хэрэгтэй: Хүчирхийллийн зэвсгийг цор ганцаараа дэмжигч эх оронч үзэл гэдэг бол хамгийн бүдүүлэг, хамгийн хор уршигтай, хамгийн ичгэвтэр, хамгийн тэнэг, тэгээд гол нь –хамгийн ёс суртахуунгүй мэдрэмж гэдгийг л ойлгож авах хэрэгтэй. Яагаад бүдүүлэг гээд байгаа юм бэ гэхээр, ёс суртахууны хамгийн доод талын гишгүүр дээр зогсож байдаг хүмүүс л дурладаг учраас тэр. Зөвхөн тэр хүмүүс л бусад ард түмнүүдийн зүгээс өөрсдийнх нь хийхээр зэхэж байгаатай адилхан хүчирхийлэл хүрээд ирчихэж магадгүй хэмээн төсөөлж байдаг. Яагаад хор уршигтай гээд байгаа юм бэ гэхээр, бусад ард түмнүүдтэй тогтоосон харилцан ашигтай, энх амгалангийн харилцааг бусниулдаг, хамгийн гол нь хамгийн муу засгийн газрыг байгуулдаг учраас тэр. Яагаад ичгэвтэр гээд байгаа юм бэ гэхээр, тэр мэдрэмж болбоос хүнийг зөвхөн боол биш, басхүү зодоонч тахиа, бух, өөрийнхөө хүч тэнхээ, амь насыг өөрийнхөө төлөө биш, засгийн газрынхаа төлөө золиосолдог гладиатор болгон хувиргадаг учраас тэр. Яагаад ёс суртахуунгүй гээд байгаа юм бэ гэхээр, Христийн сургаальд заадгаар хүмүүн бээр өөрийгөө бурханы хүү гэж биш, үгүй ядахнаа оюун ухаанаа удирдан жолоодож чаддаг чөлөөт хүн гэж бодохынхоо оронд, эх оронч үзлийн нөлөөгөөр өөрийгөө эх орны хүү, засгийн газрын боол хэмээн тооцоод оюун ухаан, сэтгэл зүрхнийхээ эсрэг үйлдлүүдийг хийж байдаг учраас тэр.

Хүмүүс энэ бүхнийг ойлгоод авуут л “засгийн газар” хэмээн нэрлэгдэгч хүмүүсийн аймшигт зууралдаан ямар ч тэмцэлгүйгээр өөрийн эрхгүй задран унаад, түүний зүгээс ард түмэндээ хүргэдэг хор хөнөөл ч хамтдаа устмой.

Үүнийг хүмүүс нэгэнт ухаарч эхэлжээ. Жишээ нь, АНУ-ын нэг иргэн ингэж бичсэн байна:

–“Тариачид, механикчид, наймаачид, үйлдвэрлэгчид, багш нар бидний хүсэн гуйдаг цорын ганц зүйл гэвэл өөрийнхөө дуртай ажлыг хийх эрх чөлөө олгоочээ л гэх байна. Бидэнд өөрийн гэсэн орон гэр бий, бид анд найз нартаа хайртай, гэр орныхондоо хязгааргүй үнэнч, бид хэзээ ч хөршийнхөө хэрэгт оролцдоггүй, бидэнд ажил төрөл байна, бид ажил хийхийг хүсэж байна.

Биднийг зүгээр л орхичих!

Гэвч улстөрчид биднийг орхиж өгөхгүй юм аа. Тэд биднийг татвараар дарамталж, өмч хөрөнгийг маань идэж ууж, толгой дараалан бүрсгэж, идэр залуусыг маань дайн тулаан руу хөөх юм аа.

Биднээс татвар авахын тулд төрийн хөрөнгөөр, төрөөр тэжээлгэн, төрөөс хамааралтай амьдрагч бүхэл бүтэн бүлэг хүмүүс байна. Татвараа санасан зоргоороо авахын тулд тэдэнд байнгын цэрэг арми байна. Эх орноо хамгаалахын тулд арми хэрэгтэй гэдэг шалтгаан бол шал худлаа. Немцүүд эх орон руу маань халдан довтлох гэж байна хэмээн Францын засгийн газар ард түмнээ айлгадаг, оросууд англичуудаас айдаг, англичууд бусад бүх ард түмнээс айдаг. Одоо харин Европ хэзээ мөдгүй бидний эсрэг нэгдээд дайрах гэж байна, тийм учраас усан флот, цэргийн тоогоо нэмэх шаардлагатай хэмээн Америк маань биднийг айлгах боллоо. Энэ нь ч мөн л худлаа зүйл. Франц, Герман, Англи, Америкийн энгийн

ардууд дайны эсрэг байгаа. Бид амар тайван байлгаад өгөөч гэж л бид хүсэж байна. Авгай, хүүхэд, гэр орон, эцэг, эхтэй биднүүс хэн нэгэнтэй нь байлдаж дайтах гэж явмааргүй байна. Бид бол эв нэгдэлд дуртай улс, бид дайныг үзэн яддаг, түүнээс байнга айж байдаг. Бусдын хийхийг хүсэхгүй байгаа зүйлийг бид ч бас хийхийг хүсэхгүй байна.

Дайн гэдэг бол зэвсэглэсэн хүмүүсийн оршин тогтнолын зайлшгүй үр дагавар.

Байнгын, их хүчтэй армитай улс орон хэзээ нэгэн цагт дайн хийж л таарна.

Нударган зодоонд мундаг гэж өөрийгөө боддог хүн өөрөөс нь дутуугүй гэж боддог хүнтэй нэгэн цагт заавал учирна, зайлшгүй зодолдоно. Герман, Франц хоёр зэр зэвсгийнхээ хүчийг бие биеийнхээ эсрэг шалгах шалтаг хүлээгээд л байна.

Тэднүүс хэд хэдэн удаа зодолчихсон, дахиад ч зодолдоно. Ард түмнүүд нь хүсээд байгаа юм биш, харин төрийн өндөрлөгүүд нь л харилцан үзэн ядалтыг бий болгоод, өөрийгөө хамгаалахын тулд байлдах хэрэгтэй гэж бодохыг ард иргэддээ даалгаад байгаа хэрэг.

Христийн сургаалийг дагагчдаас татвар хурааж, тэднийг хууран мэхлэж, доромжилж, дайн байлдаанд татан оролцуулж байна.

Христ бээр номхон хүлцэнгүй байх, гомдлыг мартаж, хүн алахыг тэнэг ажил хэмээн сургадаг. Бурханы сургааль хүмүүсийг заавал андгай тангараг тавь гээгүй, харин “Дээд анги” л биднийг итгэхгүй байгаа юман дээрээ гараа тавиад андгайлахыг шаардаад байгаа юм.

Ажил хийдэггүй мөртлөө үнэт чулуун чимэглэлтэй зэс товчтой нарийн цэмбэ өмсдөг үрэлгэн задгай хүмүүсээс, газар хагалж өгсөн хөдөлмөрийг маань сорж суудаг энэ хүмүүсээс хэрхэн ангижрах вэ?

Тэдэнтэй тэмцэлдэх гэж үү?

Гэтэл бид чинь цус урсгахыг хүсдэггүй улс, тэгээд ч тэднүүс мөнгө санга, зэр зэвсэгтэй юм болохоороо биднээс илүү удаан тэсэж чадна. Харин бидний эсрэг тулалдах тэр армийг нь хэн, хэн бүрдүүлдэг билээ? Бид л бус уу? Дайснуудаас эх орноо хамгаалснаараа бурханд алба хааж байна гэж хууртагдсан хажуу айлынхан маань, ахан дүүс маань бус уу?

Чухамдаа гэвэл, биднийг татвар өгөх юм бол ашиг сонирхлыг маань хамгаалахыг амласан дээд ангийнхнаас өөр дайсан бидэнд байхгүй. Тэднүүс л бидний шим шүүсийг сорон авч, биднийг боолчлох, доромжлохын тулд жинхэнэ ахан дүүсийг маань бидний эсрэг босгож байна.

Хэрвээ та зэвсэглэсэн хүмүүсийг тэжээх зардал болгож татвар өгөхгүй л бол өөрийнхөө ханган нийлүүлэгчид мөнгөний чек бичиж өгч чадахгүй, эхнэртээ цахилгаан, анддаа илгээлт явуулж чадахгүй. Харин тэр зэвсэг барьсан хүмүүс чинь таныг алах, шоронд суулгахын тулд л биднээс татварын мөнгө авч байгаа юм.

“Хүн алж болохгүй, бүх хууль, сургааль номын учир утга бол өөрсдийнхөө хүсэж байгаа зүйлийг бусдад ч мөн хүс” гэж сургахад л гол аврал багтах боллоо. Тэр дээр байгаа ангийг цаг ямагт үл тоомсорло, тэдний дайнч үзэл санааг тахин шүтэхээ боль. Дайныг сурталддаг, эх оронч үзлийг нэг их чухал юм шиг дэлгэрүүлдэг хүнийг дэмжихээ татгалз. Тэднүүс бидний л нэгэн адил гараа хөдөлгөж сураг.

Бид Христэд итгэдэг, харин тэд үгүй. Христ бээр өөрийнхөө бодсон зүйлийг хүмүүст ярьж өгдөг байсан, харин тэд болохоор засаглалыг баригч дээд ангийнханд таалагдахын тулд л бодож байгаа зүйлээ ярьж байдаг улс. Бид цэрэгт явахгүй. Бид тэдний тушаалаар бусдын өмнөөс буу шагайхгүй. Бид номхон дөлгөөн, сайхан сэтгэлт ард түмнийхээ өмнөөс сэлэм, жад далайхгүй. Гал голомтоо хамгаалж байгаа малчид тариачдын өмнөөс бид Сесиль Родсын тушаалаар буу онилохгүй.

Та нарын тэр “Чоно, чоно!” гэсэн худал чарлаанаар бид босон харайхгүй. Бид аргагүйн эрхэнд л та нарт татвар өгч байгаа шүү. Аргаа барагдах цагийг хүртэл л бид тэр татварыг чинь өгөх болно. Бид хуурмаг сүсэгтнүүдэд сүм хийдийн татвар өгөхгүй, та нарын тэр нүүрэндээ баг зүүсэн буянт үйлийн аравны нэгэн хувийг чинь ч авахгүй, тэр ч бүү хэл, боломж олдох бүрий үгээ хэлж байх болно.

Бид бусад хүмүүсийг хүмүүжүүлэх болно.

Бидний хэл, үггүй нөлөө хаа сайгүй түгэн тархах болно, цэрэгт татагдсан залуус маань та нарт эргэлзээд, байлдах, дайтахаасаа татгалзах болно. Энэ хорвоогийн Христ ёсны чөлөөт амьдрал маань дайн тулаан, урсах цус, тэмцлээс чинь илүү гэдэг сэхээрлийг бий болгоно.

“Энэ газар шороон дээр энх амгаланг тогтооё!” гэсэн уриа цэрэг цуухаасаа ангижирч, өөрсдийнхөө хүсэж байгаа зүйлийг бусдад ч мөн адил хүсэж эхлэх тэр цагт биеллээ олно”.

АНУ-ын жирийн иргэн ийнхүү бичсэний нэгэн адил утга санаатай дуу хоолой даян дэлхийн өнцөг булан бүрээс цуурайтаж байна.

Нэгэн герман цэргийн бичсэнийг одоо сонирхоё:

-“Миний бие Пруссийн гвардийн эгнээнд хоёр удаа аян дайнд (1866-1870 онуудад) оролцсон болохоор дайныг үнэн голоосоо үзэн ядаж байна, яагаад гэвэл түүнээс болоод айхтар их зовлонд унасан. Дайнд шархадсан цэргүүд бидний авдаг өчүүхэн төдий тэтгэмжээ бодохоор нэгэн цагт эх оронч хүмүүс байсан гэдгээсээ ичихэд хүрдэг. Жишээ нь, би 1870 оны наймдугаар сарын 18-нд Прива тосгоныг дайрах үед хуга буудуулсан гарныхаа төлөө өдөрт ердөө л 80 пеннинг авдаг. Харин анч нохойд бол түүнээс арай илүү илүү юм оногдох нь гарцаагүй. Гэтэл хоёр удаа хуга буудуулсан гараасаа болоод олон жил тарчилсаан. 1866 оноос би Австрийн эсрэг байлдаанд оролцож, Траутенау, Кенигрипын дэргэд нүдэлдэж, аймшиг гэдэг юмыг залхатлаа үзсэн. 1870 онд бэлтгэл цэрэг байсан боловч дахиад л цэрэгт татагдан, дээр хэлснээр Прива тосгоны дэргэд шархадсан юм. Баруун гарыг маань хоёр сум хаван орсон. Уг нь би дайнаас өмнө шар айраг исгэдэг байсан боловч шархадсанаасаа хойш хөл дээрээ босож чадах минь өнгөрсөн. Мунхрал маань тун удалгүй сарнисан ч, тахир татуу хуучин цэрэг би хэдхэн сохор зоос, өглөг буяны хүчээр л амь зууж байна...”

Хүмүүс нь сургуультай амьтад шиг ийшээ тийшээ үсэрч дэгдэж явдаг энэ хорвоо дээр ходоодныхоо л төлөө бие биеэ хэрхэн мэхлэх вэ гэдгээс өөр бодол санаа байдаггүй юм байна. Ийм орчлонд хүн бүр л намайг “хачин хүн” гэх боловч би сургааль номонд тэгтлээ сайхан бичигдсэн хорвоо ертөнцийг дандаа сайн сайхнаар төсөөлж явдаг аа. Миний ойлголтоор бол дайн гэдэг тэр юм чинь том хэмжээний арилжаа наймаа юм байна. Хүчирхэг бөгөөд нэр хүндэд дуртай хүмүүсийн зүгээс ард түмний аз жаргалаар наймаалцах ажил!

Дайны талбар дээр ямар гээчийн аймшгийг олж харна гээч! Чөмгөнд минь хүртэл сонсогдох орийн дуу тавьсан ёолооныг хэзээ ч мартаж чадахгүй дээ. Урьд нь хэзээ ч бие биендээ муу санаж яваагүй хүмүүс яг л зэрлэг араатан лугаа адил бие биеэ алж талж, өчүүхэн муусайн боолын сэтгэлтнүүд сайхан сэтгэлт бурхадыг орлодог юм. Хажууд минь зогсдог жагсаалын андын маань эрүүг хуга буудсан. Хөөрхий тэр маань өвдсөн болоод галзуурах шахаж, хайлам халуун наранд ийш тийшээ гүйвч өвдөлтийг нь бага ч гэсэн дарахын тулд балга ус олох гээд чадаагүй юм. Харин тэр үед манай дарга, титэм өвлөх гүн Фридрих (Сүүлдээ эрхэм дээд эзэн хаан Фридрих) тэмдэглэлийнхээ дэвтэрт “Дайн гэдэг бол Евангелийн нөхөрсөг шог юм даа...” хэмээн бичсэн байсан гэдэг”.

Одоо тэгэхээр засгийн газруудын ингэтлээ шаргуу зүгшрүүлэх гээд байгаа эх оронч үзлийн хуурамч дүрийг хүмүүс таньдаг болж эхэллээ.

8

“Хэрвээ засгийн газрууд гэж байхгүй болчих юм бол юу болох вэ?” хэмээн асуух нь олонтаа тохиолддог.

Сүйдтэй юм юу ч болохгүй. Үгүй болсон юм л үлдэнэ, нэгэн цагт байсан, тийм болохоор илүүдэл, хортой болох нь мэдэгдсэн тэр нэгэн эд эс хэрэггүй болоод, хортой болсон чигээрээ л өнгөрнө.

“Засгийн газрууд гэж байхгүй болчих юм бол хүмүүс бие биеэ алж талаад, хүчирхийлээд эхэлнэ шүү дээ” хэмээн адрах нь бий.

Яагаад? Хүчирхийллийн ачаар бий болсон, хүчирхийллийг үйлдэхийн тулд үеэс үе дамжин ирсэн тэр байгууллагыг, хэрэгцээ нь нэгмөсөн өнгөрсөн тэр байгууллагыг устгаснаар хүмүүс яагаад бие биеэ алж тална, хүчирхийлнэ гэж? Харин ч хүчирхийллийн байгууллагыг үгүй болгосноор хүмүүс бие биеэ алж, хүчирхийлэхээ болино шүү дээ.

Бусад хүмүүсийг алж талах, хүчирхийлэх зорилгоор тусгайлан бэлтгэгдсэн, зориуд хүмүүжигдсэн хүмүүс бий. Тэр хүмүүст хүчирхийллийн эрх чөлөөг олгосон, тэднүүс л үүний тулд зориуд бий болгосон байгууллагаа ашигладаг. Хүчирхийлэл хийгээд алаан хядаан бол тэдний хувьд сайн сайхан, эр зоригийн үйл хэрэг. Харин засгийн газрыг үгүй болгочих юм бол хүмүүсийг хүчирхийлэлд зориулан бэлтгэхгүй, бусдыг хүчирхийлэх эрх хэнд ч байхгүй болно, хүчирхийллийн байгууллага ч үгүй болно, тэгсэн цагт өнөө үеийн зарим хүмүүсийн сэтгэхүйд шингэчихээд байгаа шигээр хүчирхийлэл хийгээд алаан хядаан хэн бүхний хувьд тэнэг үйлдэл гэж тооцогдох болно.

Засгийн газрыг үгүй болгосны дараа ч хүчирхийлэл гараад байх юм бол тэр нь одоогийнхыг бодвол хамаагүй цөөн тоотой тохиолдоно. Хүчирхийллийг үйлдэх тусгайлсан байгууллага, зөвшөөрөл, дүрэм байгаа учраас л хүчирхийлэл, аллага хоёр сайн сайхан, ашигтай үйл хэрэгт тооцогдоод байгаа юм.

Засгийн газруудыг үгүй болгосноор үе дамжин ирсэн хүчирхийллийн зохион байгуулалтыг давхар устгаж, түүнийг зөвтгөхөө болино.

“Тэр цагт чинь хууль ёс ч, өмч хөрөнгө ч, шүүх, цагдаа ч, ардын боловсрол ч үгүй болно” хэмээн нийгмийн төрөл бүрийн үйл ажиллагааг засаглалын хүчирхийлэлтэй зориуд холин будилах нь бий.

Хүмүүсийг хүчирхийлэх үйл ажиллагааны зорилгоор байгуулагдсан засгийн газрын байгууллагуудыг устгаснаар хууль ёсыг ч, өмч хөрөнгийг ч, шүүх, цагдааг ч ардын боловсролыг ч, санхүүгийн байгууллагуудыг ч устгах шаардлага гарахгүй. Зөвхөн

өөрийнхөө оршин тогтнолыг хангах зорилготой засгийн газрын харгис эрхийг үгүй хийснээр хүчирхийлэл огтоос хэрэггүй олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаанд харин ч дэмжлэг болно. Шүүх , олон нийтийн ажил, ардын боловсрол гээд бүх үйлчилгээ ард түмний хэрэгцээний хэрээр л төлөвшөөд, ард түмний хүсэл зоргын чөлөөт илрэлд садаа болж байсан бүхэн нь устана.

Засгийн газар байхгүй болсноор далимдуулан дотоодын будилаан, самуун гарлаа ч гэсэн ард түмний амгалан байдал одоогийнхтой зүйрлэвээс хамаагүй тогтвортой байна. Ард түмний одоогийн байдлыг аваад үзэх юм бол, үүнээс дор юм гэж байх уу даа гэмээр бус уу? Ард түмэн хоосорчээ, Энэ хоосрол цаашдаа ч хүчлэн үргэлжлэх нь зайлшгүй. Бүх эрчүүл цэргийн боол болон хувирсан болохоор хэн нэгнийг алах, эсвэл өөрөө алагдах тушаал ирэх хором бүрийг хүлээж сууна. Өөр юу хүлээх юм бэ? Хоосорсон ард түмнээ турж үхэхийг хүлээх болж байна уу? Тэгвэл тэр чинь Орос, Энэтхэг, Италид тулж ирчихээд байна. Аль эсвэл, эрчүүлийн хажуугаар бас хүүхнүүдээ цэрэгт татаж эхлэхийг хүлээх гээд байгаа юм уу?

Трансваальд тэр чинь эхэлчихээд байгаа шүү дээ.

Засгийн газруудыг үгүй хийснээр анархизмыг төрүүлнэ гэж айгаад байгаа бол, анархистуудын ямар ч эмх замбараагүй явдал засгийн газруудын зүгээс ард түмэндээ хүргэсэн бөгөөд ирээдүйд хүргэх хэмжээлшгүй их хортой харьцуулшгүй бага байх болно.

Энэ бүхнээс үзэхэд хүмүүсийг эх оронч үзлээс чөлөөлөх, эх оронч үзэл дээр суурилагдсан засгийн газрын харгислалыг устгах нь ашиггүй байх үндэсгүй.

9

Ухаарцгаа хүмүүс ээ, хамаг сайн сайхныхаа төлөө, махан бодын хийгээд сэтгэл санааныхаа эрхэм сайхны төлөө ухаарцгаа! Ах, эгч, дүү нарынхаа сайн сайхны төлөө санаа зовоод, юу гээчийг үйлдэж байгаагаа эргэцүүлэн бодоцгоо!

Ухаарцгаа, басхүү та нарын дайснууд чинь англичууд ч биш, бурчууд (Одоогийн ӨАБНУ, Намибийн нутагт оршин суудаг цагаан арьстан үндэстний цөөнх. Орч) ч биш, немец, чех, финлянд, оросууд ч биш, та нарын дайснууд бол эх оронч үзлээр өөрсдийгөө дарлан мөлжигч та нар өөрсдөө болон та нарын зовлон гачаалыг төрүүлэгч засгийн газрууд чинь юм шүү.

Засгийн газрууд чинь та нарыг аюул заналаас хамгаалах үүрэгтэй боловч энэхүү хуурамч үүргээ та нарыг цэрэг, барлаг болгож, хамаг юмыг чинь сүйрүүлснээр хязгаарлаж байгаа болохоор чангалан татсан утас шиг гэнэт л нэг хоромд тас үсрээд, таныг ч, хүүхдүүдийг чинь ч аймшигтайгаар тамлах болно.

Тэр тамлал нь хичнээн айхтар байлаа ч гэсэн, яаж ч төгслөө гэсэн нөхцөл байдал огт өөрчлөгдөхгүй. Засгийн газрууд чинь урьдынхаасаа ч улам илүү зэвсэглээд, таныг ч, таны хүүхдүүдийг ч улам л самууруулах агаад хэрвээ та л өөрөө өөртөө туслахгүй юм бол хэн ч түүнийг зогсоож үл чадмой.

Энд ганцхан л тус буй. Хүчирхийллийн конусын аймшигт барьцалдааныг л устгах! Чухамхүү тэр конус байгаа учраас л орой дээр нь гарсан хэн ч байлаа гэсэн ард түмнийг бүхэлд нь дарангуйлан, бидний мэддэг Наполеонууд, 1-р Николайнууд, Бисмаркууд, Чемберленүүд, Родсамууд хийгээд эзэн хааны нэрийн өмнөөс ард

түмнээ азаргалж байдаг манай дарангуйлагч нарын жишээгээр улам илүү харгис, улам илүү хүнлэг бус засаглалаа барьсаар байх болно.

Харин энэхүү барьцалдааныг тасар татахын тулд ганцхан л арга хэрэгтэй. Тэр бол эх оронч үзлийн ховсноос гарах.

Та нарын зовлон шаналлын эх сурвалж бол эзэд хаад, ван, гүн, парламентын гишүүд, цэргийнхэн, эрх баригчид, капиталистууд, санваартнууд, зохиолчид, зураачдад дөрлүүлсэн та бүхнээс өөрсдөөс чинь болж байгаа гэдгийг сэхээртүгэй! Тэднүүс л та нарын хөдөлмөрийг шимэн амьдрахын тулд эх оронч үзлийн хуурмаг дүрийг босгосон юм.

Та хэн ч байлаа хамаагүй, франц, орос, польш, англи, ирланд, немец, чех ялгаагүй, таны жинхэнэ хүсэл сонирхол газар тариалан, аж үйлдвэр, худалдаа, уран зохиол, эрдэм шинжилгээний салбар байлаа ч адилхан, таны сонирхол баяр хөөр, хүсэл тэчьеэлээсээ үл хамааран бусад ард түмэн, ямар ч төр улсын сонирхолтой огт зөрчилдөхгүй, аливаа ард түмний иргэн бүрийн ахан дүүсэг өргөн харилцааны найрсал, үйлчилгээний солилцоо, харилцан туслалцаа байтугай, дотоод мэдрэмж, бодол санаа ч холбоотой байдаг юм шүү.

Вей Хай-вэй, Порт-Артур, аль эсвэл Кубыг хэн эзлэн түрэмгийлж чадсан бэ, танай засгийн газар уу, өөр засгийн газар уу гэдэг нь танд огт хамаа байхгүй, харин тэр засгийн газар тийм алхам хийснээр танд хор хүргэж байгаа юм, яагаад гэвэл энүүгээрээ дамжуулан засгийн газар чинь таныг өөрийнхөө эзлэн авах түрэмгий ажиллагаа, хүчирхийлэл, дээрэм тонуулд оролцуулахын тулд танд дарамт үзүүлнэ. Эльзас немцүүдэд эсвэл францчуудад очих, Ирланд эсвэл Польш чөлөөт байх, эзлэгдэхийн аль нь ч танд хамаагүй, аль ч гүрний эрхшээлд байлаа гэсэн ялгаагүй, эльзас, ирланд, польш ямар ч үндэстэн байлаа танд хамаагүй, хүссэн газраа аж төрөх болно гэдгийг ойлготугай! Хамгийн гол нь эх оронч сэтгэлийг дэвэргэх нь л таны хувьд хамгийн хортой, яагаад гэвэл танай ард түмэн боолчлолд орсон нь эх оронч үзлийн л тэмцлээс болоод байгаа юм, ямар ч үндэстний эх оронч үзлийн аливаа илрэл нөгөө үндэстнийхээ зүгээс эсэргүүцэлтэй тулгардаг гэдгийг санагтун! Үеэ өнгөрөөж буй эх оронч үзэл, түүн дээр суурилагдсан засгийн газартаа хүлцэнгүй хандах зангаасаа ангижирч, бидний амьдралын хүрээнд нэгэнт хүчтэйгээр орж ирээд байгаа ард түмнүүдийн ахан дүүгийн нөхөрлөлийн эрхэм дээд үзлийн салбар луу зоригтойёо алхан орсон тэр цагт л таны бүх зовлон гачаалын аврал ирнэ гэдгийг бүү мартагтун!

Хүмүүс өөрсдийгөө ямар нэг эх орон, засгийн газрын хүүхэд биш, бурханы л хүүхэд гэдгийгээ, өөр бусад хүмүүсийн боол ч биш, дайсан ч биш гэдгийгээ ойлгох юм бол “засгийн газрууд” гэгдэх, бүр эртэн цагаас хөнөөлт үүрэг бүхий, одоо бол ямар ч хэрэггүй тэнэг байгууллагууд, түүний салшгүй эд эс болсон зовлон шаналал, хүчирхийлэл, доромжлол, гэмт хэргүүд аандаа устгах болмуй.

